

## “ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК -ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2026.01.18

### Нэг. Зорилго, арга зүй

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” /ХХНОБ/ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

### Хоёр. Танилцуулга

ХХНОБ ТӨХХК-ийн үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85.5%**-тай үнэлэгдлээ.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

#### 2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
1	1	-	-	-	100%

**2.2. ХХНОБ ТӨХХК-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
16	14	2	-	-	99,2

**2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
6	4	-	-	-	2	100%

**2.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:**

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	0%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0%
<b>Дүн</b>		<b>0%</b>

**2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
180	180	180	-	-	100%

**Гурав. Үнэлэлт, дүгнэлт**
**1. Төлөвлөлтийн байдал:**

ХХНОБ ТӨХХК нь ХШУДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

## 2. Хэрэгжилтийн байдал:

1) ХХНОБ ТӨХХК-ийн үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 85.5%-тай үнэлэгдлээ.

2) “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу shilen.gov.mn сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс 0%-аар үнэлэгдсэн байна.

3) 2024 он, 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн дараах зөвлөмжүүд хэрэгжсэн байна. Үүнд.

- Чингис хаан” ОУНБ-ыг өргөтгөх, цаашид олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгон өргөжүүлэх чиглэлээр судалгааны ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагч талд тавьж шийдвэрлүүлэх;
- АНУ руу шууд нислэг үйлдэхтэй холбоотой хийгдсэн TSA-ийн шалгалтаар “Чингис хаан” ОУНБ-д одоо хэрэглэгдэж байгаа, үзлэг шалгалтын зарим төхөөрөмжүүдийг шинэчлэх зөвлөмж өгсөний дагуу шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

4) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 дүгээр сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт”-д дотоод аудит хийхэд ХХНОБ ТӨХХК-ийн хэрэгжилт 67%-тай үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ҮАГ	9	6	-	67%

5) “Чингис хаан” ОУНБ 2025 онд 19,854 нислэг, 12,500 тн карго ачаа хүлээн авч, 2,448,413 зорчигчид үйлчилсэн байна. Энэ нь 2024 онтой харьцуулахад нислэг 12.8%, зорчигч 12.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6) “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд нийт 84 удаагийн нислэгээр Монгол Улсаас гадаад улсад хийх болон гадаад улсаас Монгол Улсад хийх төрийн өндөр дээд хэмжээний айлчлал, олон

улсын хурал, форумын оролцогчид зэрэг албаны нийт 1,772 тусгай үйлчлүүлэгч, үүнээс 1,430 зорчигч, 342 утгагч, үдэгчдийг “Чингис хаан” ОУНБ-д угтан авах, үдэн гаргах үйлчилгээг үзүүлжээ.

7) ХХНОБ ТӨХХК нь Хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого 1097.0 сая төгрөг, ногдол ашгийн орлого 13,360.8 сая төгрөг, хүүгийн болон бусад орлого 1082.2 сая төгрөг, нийт 15,540.1 сая төгрөгийн орлого олж, 2025 оны орлогын төлөвлөгөөг 119 хувь давуулан биелүүлж, нийт зардлыг 27 хувиар хэмнэн 11.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт 2.1 тэрбум төгрөгийн орлого, төрийн өмчийн ногдол ашгийн төлбөрт 7.3 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

### **Дөрөв. Санал, зөвлөмж**

1. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;
2. “Чингис хаан” ОУНБ-ыг өргөтгөх, “Эйрпорт зочид буудал” байгуулах ажилд хамтран ажиллах;
3. Байгууллагын эрсдлийг тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах;
4. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт материалын хамт бүрэн тайлагнаж ажиллах;
5. 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
  - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх;
  - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам болон бусад харьяа байгууллага, компаниудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК -ИЙН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	1	1	100	20
2	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	16	16	99.2	20
3	Сайдын тушаалын хэрэгжилт	6	3	100	10
4	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	45	45	0	10
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	180	180	100	10
<b>Нийт</b>				<b>85.5</b>	